



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 01

Бүрэнхайрхан

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол улсын хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга- Сумын ИТХ-ын дарга

Орлогч дарга- Сумын Цагдаагийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга- Сумын Цагдаагийн хэлтсийн хэв журмын байцаагч

Гишүүдэд: Сум дундын шүүхийн Тамгын газрын дарга

Сум дундын Прокурорын газрын ахлах прокурор

Сумын Засаг даргын орлогч

Сумын ЗДТГ-ын Дотоод ажил, эрх зүйн бодлогын мэргэжилтэн

Сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн

Сумын Далт багийн Засаг дарга

Сумын Бүрэнхайрхан багийн Засаг дарга

Сумын 1 дүгээр бүрэн дунд сургуулийн нийгмийн ажилтан

Сумын Минжит Булган цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

Сумын нэгдсэн эмнэлэгийн эрхлэгч эмч

2. Сумын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам хангах ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж явц үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хагас, бүтэн жилээр илтгэж байхыг зөвлөлийн орлогч даргад үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2016 оны 01 дүгээр сарын 22-ны 05 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА Т. БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 02

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 18.1.3-ийн “ж”, 20 дүгээр зүйлийн 20.1.7, 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “в” дахь заалтууд, сумын Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1.Тус суманд “Сум тохижилтын алба” байгуулах саналыг дэмжсүгэй.
- 2.Сум тохижилтын албаны орон тоо, ажиллах албан хаагчийн цалин хөлсийг Засаг даргын Тамгын газрын цалингийн санд багтаан олгохыг Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д зөвшөөрсүгэй.
- 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2013 оны 04 дүгээр сарын 05-ны 30, 2014 оны 07 дугаар сарын 01-ний 5/06, 2015 оны 03 дугаар сарын 18-ны 13 тоот тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 03

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам" сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Пагма овогтой Баастыг төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-оор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Т. БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 04

Бүрэнхайрхан

2017 оны ажлын төлөвлөгөө
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, ажлын албаны 2017 оны ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Т. БАТХУЯГ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр
тогтоолын хавсралт

БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.01.13.

Бүрэнхайрхан

д/д	Хийх ажлын чиглэл	Хугацаа	Хариуцах эзэн	Биелэлт
1. Сумын ИТХ-ын хуралдаан				
1	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дүгээр зүйлийг удирдлага болгон ажиллах	жилдээ	Хурлын ажлын алба	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангаж ажиллах	Хагас бүтэн жил	Хурлын ажлын алба	
2. Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудал				
3	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дүгээр зүйлийг удирдлага болгон ажиллах	Тухай бүр	Хурлын ажлын алба	
4	Орон нутгийн өмчийн данс бүртгэлд байгаа ашиглахгүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн өмчийн албанд хүргүүлэх	1 дүгээр улиралд	Ш.Азжаргал А.Бурмаа	
5	Төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах тухай асуудлыг шийдвэрлэх	Тухай бүр	А.Бурмаа Тэргүүлэгчид	
6	Баг, байгууллага, Засаг даргын Тамгын газрын албадуудын тайлан мэдээлэл тогтмол сонсож зөвлөмж өгч ажиллах	Улирал тутам	Тэргүүлэгчид	
7	2017 онд хяналт шалгалтын график гаргаж ажиллах /дотуур байр, үдийн цай, тендэр, аж ахуйн нэгж, байгууллагуудад/	Улирал тутам	Тэргүүлэгчид	
8	2017 онд нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт урлагийн арга хэмжээ, сургалт зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөө батлах тухай	Тухай бүр	Тэргүүлэгчид	

9	иргэдээс өргөдөл томдлыг хүлээн авах, бүртгэх, хяналт тавих, хариу өгөх ажлыг шуурхай зохион байгуулж тайлан мэдээ гаргах			
10	Нутаг дэвсгэртээ сахилга, дэг журмыг хангахаар чиглүүлж буй хөтөлбөр, төслийг дэмжин ажиллах	Тухай бүр	Тэргүүлэгчид	
11	Нийтийн сонсгол зохион байгуулах	2017.02.03	Ажлын алба Д.Ууганжаргал	
12	2016 оны сумын ажил, мэргэжлийн аварга шалгаруулах	2017.02	Тэргүүлэгчид	
13	Багийн иргэдийн Нийтийн Хурал зохион байгуулах, чиглэл, зөвлөмж өгч ажиллах	Улирал тутам	А.Бурмаа	
14	Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, улс, аймаг, сумын 2016-2020 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөны биелэлтийг тооцож холбогдох газарт хүргүүлэх	Улирал тутам	А.Бурмаа	
15	Сумын өвөлжилт хаваржилт, цаг үеийн ажил асуудлаар Засаг даргын орлогчийн мэдээлэл сонсох	Тухай бүр	Тэргүүлэгчид	
16	Төрийн бус байгуулагуудын судалгаа гаргаж, хамтран ажиллах	Тухай бүр	А.Бурмаа	
17	Төрийн дээд шагналд тодорхойлох	Тухай бүр	Тэргүүлэгчид А.Бурмаа	
18	Сумын төсвийн 2017 оны ОНХС-аас санхүүжүүлэх арга хэмжээний тухай мэдээллийг цаг тухайд Хурлын ажлын алба, Тэргүүлэгчдэд өгч байх	Хагас бүтэн жилээр	Тэргүүлэгчид	
3.Хороод				
19	Хурлын хороодын үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөөг батлан мөрдөж ажиллах	1 дүгээр улиралд	Хороо тус бүр	


20	Сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлуудыг урьдчилан бэлдэж хороодоор хэлэлцүүлэн дүгнэлт оруулж, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг томилж ажиллуулах, Төлөөлөгчид, хороодыг цаг үеийн болон холбогдох мэдээ мэдээллээр хангаж ажиллах			
21	Иргэний танхимд хэлэлцүүлгүүд зохион байгуулах	Тухай бүр	Ш.Ганболд А.Бурмаа	
22	2017 онд хяналт шалгалтын график гаргаж ажиллах /дотуур байр, үдийн цай, тендэр, аж ахуйн нэгж, байгууллагуудад/	Улирал тутам	Тэргүүлэгчид	
4. Төлөөлөгчдийн өдөр				
23	Баг сурталчилах үзэсгэлэн худалдаа өдөрлөг зохион байгуулах	улиралаар	Багийн ИНХ-ын дарга	
24	Хилийн суман, хил дагуу байгаа малчидтай уулзах тэдний саналыг сонсох, монгол улсын дархан хилийн байдалтай танилцах	Жилд 2 удаа	Т.Батхуяг	
25	Сар бүр төлөөлөгчдийн уулзалт зохион байгуулж, мэдээлэл өгч санал солилцож ажиллах	Сар бүр	Тэргүүлэгчид А.Бурмаа	
26	Төлөөлөгчдийн өдөрлөгийг жилд 1 удаа зохион байгуулах	12 сард	Ажлын алба	
5. Хяналт шалгалтын ажиллагаа				
27	ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгүүдийн мэдээлэл сонсох	Тухай бүр	Тэргүүлэгчид	
28	Хороод тус бүр холбогдох чиглэлээр байгууллагуудад ажиллах, зөвлөмж, арга зүйгээр хангах, хяналт шалгалт хийх ажлын удирдамж гарган ажиллах	Тухай бүр	Ажлын алба	
29	Сумын ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрүүдийн биелэлтийг тооцож, үр дүнг Тэргүүлэгчдийн хуралдаанд мэдээлэх	4 дүгээр улиралд	А.Бурмаа	
30	Төсөл хөтөлбөр, тендерийн үйл ажиллагаанд хяналт хийнэ.	Улирал бүр	Тэргүүлэгчид	

31	Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг Ховд аймагт сургалтанд хамруулах	жилдээ	Т.Батхуяг Ажлын алба	
32	НӨУБ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, "Иргэний танхим"-ыг байнгын үйл ажиллагаатай болгох, ажиллах журам боловсруулах	Тухай бүр	Ажлын алба	
33	Багуудын ИНХ-ын дарга нарыг техник тоног төхөөрөмжөөр хангах	2 дугаар улиралд	А.Бурмаа	
34	Багуудын иргэдийн Нийтийн Хурлын дарга, тэргүүлэгчдэд сургалт зохион байгуулах, ажлыг нь дүгнэх журам боловсруулж, хяналт, зөвлөгөө өгч ажиллах	1 дүгээр улирал	А.Бурмаа	
35	Сумын ИТХ-ын вэб сайт, faseboос хуудас нээн мэдээллийг тухай бүр тавьж иргэдэд хүргэж ажиллах	Тухай бүр	А.Бурмаа	
36	Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргыг Удирдлагын Академийн модульт сургалтанд хамруулах	улиралаар	Т.Батхуяг	
37	Тэргүүлэгчдийг сургалтанд хамруулах	Тухай бүр	А.Бурмаа	
7.Өмч хөрөнгө бүртгэл , санхүүгийн тайлан,мэдээ				
38	Байгууллагуудын хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавин холбогдох мэдээ тайланг тухай бүрд нь холбогдох байгууллагад хүргүүлэх	Тухай бүр	А.Бурмаа Ш.Азжаргал	
39	2016 онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, бусад төсөл хөтөлбөрөөр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах	Тухай бүр	Ш.Азжаргал Д.Батцэцэг	
40	Орон нутгийн өмчийн тайлан мэдээг хугацаанд нь авч байх	Тухай бүр	Ш.Азжаргал Д.Батцэцэг	
41	ИТХ-ын санхүүгийн тайлан мэдээг сар бүр авч хяналт тавьж өр авлагагүй ажиллах	Тухай бүр	Т.Батхуяг А.Бурмаа	
8.Дотоод ажил				
42	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дэг батлуулж мөрдөн ажиллах	1 улирал	А.Бурмаа	

	хавтаслан архивт хадгалуулах			
44	Ажлын албаны ажилтнуудын 2017 оны ээлжийн амралтын хуваарийг баталж хэрэгжүүлэх	I улирал	А.Бурмаа	
45	Ажлын албаны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг гаргах, үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээг дүгнэж ажиллах	I улирал	А.Бурмаа	
46	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, тайлагнах, мэдээлэх ажиллагааг цахим системд шилжүүлэх	Тухай бүр	А.Бурмаа	
47	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах эрх бүхий албан тушаалтанд сургалт зохион байгуулах	Тухай бүр	А.Бурмаа Ш.Ганболд	
48	Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар мэдээлэл авахыг хүссэн иргэдэд зохих журмын дагуу мэдээлэл олгох	Тухай бүр	А.Бурмаа	
49	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг шинэчлэн төлөвлөгөө гарган ажиллуулах	Тухай бүр	Т.Батхуяг	
50	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдөр, хүний эрхийн өдрийг тусгай төлөвлөгөөтэй тэмдэглэн өнгөрүүлэх	Тухай бүр	А.Бурмаа	
51	Төлөөлөгчид, хороодын хийсэн ажлын тайлан мэдээг тухай бүр нь авч ажиллах	Тухай бүр	А.Бурмаа	
52	Үндсэн хуулийн өдрийг төлөвлөгөөтэйгөөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг эрхлэн зохион байгуулах	Тухай бүр	Ш.Ганболд А.Бурмаа	
53	Хөрш орон, тэдгээрийн иргэд, байгууллагын түвшинд харилцах харилцааг өргөжүүлэн Хурлын сонгуультаан, ажилтнуудыг туршлага судлах ажлыг хэрэгжүүлэх	Тухай бүр	Т.Батхуяг А.Бурмаа	
54	"Нутгийн удирдлага" сэтгүүлийн захиалгыг нэмэгдүүлэх, түүнд орон нутгийн НӨУБ-ын ажлын мэдээлэл, шинэ санаачлагын талаар нийтлэл хэвлүүлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	А.Бурмаа	

	болгон, хурлын үйл ажиллагааг сурталчлах			
56	Сумын ИТХ-ын Ажлын албаны 2016-2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016 оны төсвийн төслийг боловсруулж хянуулан батлуулах	III улирал	А.Бурмаа Ш.Азжаргал	
57	Сумын ИТХ-ын Ажлын албаны төсвийн 2016 оны санхүүгийн тайланг гаргаж тушаах	I улирал	А.Бурмаа Ш.Азжаргал	
58	Хурлаас зохион байгуулсан ажлын сарын мэдээллийг гаргаж аймагт хүргүүлэх болон сумын нийт иргэдэд мэдээлэх	Сар бүр	А.Бурмаа	
59	"Цагаан сар" хэлэлцүүлэг зохион байгуулах	1.14-нд	А.Бурмаа	
60	Төлөөлөгч, ажлын албаны ажилчдын хувийн хэргийн бүрдэлтийг журмын дагуу бүрдүүлэн ажиллах	1 дүгээр сард	А.Бурмаа	
61	Хуулийн ганцаарчилсан зөвлөгөө, уулзалт, лавлагаа өгч ажиллах	өдөр бүр	А.Бурмаа	
62	Ажлын байрны соёл удирдамж боловсруулан дүгнэж ажиллах	Хагас бүтэн жилээр	А.Бурмаа	
63	Улаан загалмайн үйл ажиллагааг тогтмолжуулан ажлыг эхлүүлэх	Тухайн жилдээ	Т.Батхуяг	

Төлөвлөсөн ____, биелэсэн ____, тасарсан ____, хувь ____

БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  А.БУРМАА



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 05

Бүрэнхайрхан

Ой тэмдэглэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, сумын Засаг даргын саналыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1.Булган сумын Нэгдсэн эмнэлэгийн 80 жилийн ойг 2017 оны 09 сарын 15, 16, 17-ны өдрүүдэд тэмдэглэсүгэй.

2.Нэгдсэн эмнэлэгийн 80 жилийн ой угтаж бүтээн байгуулалтын ажлуудыг хийж, ой тэмдэглэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг дарга /Б.Батбаатар/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 06

Бүрэнхайрхан

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д”, 20 дүгээр зүйлийн 20.1.7 дахь заалт, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум тохижилт үйлчилгээний албаны ажиллах журмыг нэгдүгээр хавсралт, зарим төрлийн үйлчилгээний хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сум тохижилт үйлчилгээний албаны ажиллах журмыг хангуулж, үнэ тарифийг мөрдүүлэн ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ

"СУМ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА"-НЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Сумын тохижилт орчны ариун цэврийг хангаж нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулан засвар үйлчилгээг хийж хариуцсан техник, тоног төхөөрөмжийг ариг гамтай бүрэн бүтэн ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сумын "Сум тохижилт үйлчилгээний алба"-ны бүрэлдэхүүнд дарга, жолооч, үйлчилгээний гэрээт ажилчин, гудамжны гэрээт үйлчлэгчид багтана.

1.3. Сумын "Сум тохижилт үйлчилгээний алба"-ны дарга орон нутгийн төсвөөс бусад ажилчид гэрээтээр үйлчилгээний хураамжийн орлогоос цалинжина.

1.4. Үйлчилгээний орлогыг албаны дарга сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоосон тарифаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албанаас олгосон квитанцаар хурааж дансанд төвлөрүүлнэ.

1.5. Сумын "Сум тохижилт үйлчилгээний алба"-ны дарга, сумын Засаг даргатай үр дүнгийн гэрээтэй, ажилчид албаны даргатайгаа хөдөлмөрийн гэрээтэй ажиллана.

1.6. Сумын "Сум тохижилт үйлчилгээний алба"-ны дарга Засаг даргын Тамгын газарт цаг бүртгүүлж ажлаа тайлагнаж ажиллана.

Хоёр. "Сум тохижилт үйлчилгээний алба"-ны хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх, иргэдэд үйлчилгээг тогтмол хөнгөн шуурхай хүргэнэ.

2.2. Сумын засмал зам, гудамжны гэрэлтүүлэгүүд, нийтийн эзэмшлийн зам талбай, байгууламжуудын өмч хөрөнгийн хамгаалалтыг хариуцан, засвар үйлчилгээг тогтмол хийж ажиллана.

2.3. Төвийн аж ахуйн нэгж, байгууллагуудын орчны тохижилт, засвар үйлчилгээнд хяналт тавьж хэрэгжилтийг нь хангуулна.

2.4. Сумын төвийн гудамж талбайн хог хаягдал, бие засах газар, муу усны цооногийн хэвийн ажиллагааг хангаж байнгын ажиллагаатай байлгана.

2.5. Сумын ИТХ-ын тэргүүлэгчдээс тогтоосон тарифаар аж ахуйн нэгж, байгууллага, ТҮЦ, дэлгүүр, гуанз, тоглоомын газар, зочид буудал, рестароноос хураамж авч санхүүгийн эх үүсвэр хуримтлуулна.

2.6.Багуудын Засаг дарга нартай хамтран иргэдэд холбогдох хууль тогтоол шийдвэр сурталчлан, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

2.7.Машины жолоочид тракторыг хариуцуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагад үйлчилж тогтоосон тарифаар хураамж авна.

2.8.Нийтийн халуун усны үйлчилгээний хэвийн ажиллагааг хангуулж удирдлагаар хангаж ажиллана.

2.9.Гүний худгуудыг тогтмол ажиллуулж иргэдийг ундны цэвэр усаар хангаж байна.

_____оОо_____

ЗАРИМ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

а/. Хогны үйлчилгээ

1. Зочид буудал, ресторан	15000 төгрөг	
2. Томоохон дэлгүүрүүд	10000 төгрөг	
3. Дундаас доош үйлчилгээний дэлгүүр	5000 төгрөг	
4. Цайны газар	5000 төгрөг	
5. Үсчин, гутал засвар	10000 төгрөг	
6. Сумын төвд амьдарч байгаа айл өрх	10000 төгрөг	
7. Шатахуун түгээх станц	10000 төгрөг	
8. Бусад	5000 төгрөг	
9. Нэг машин хог захиалагч өөрөө ачихид		30000 төгрөг
10. Нэг машин хогийг 2 ачигчийн хамт захиалж ачихид		50000 төгрөг

Айл өрхөөс

11. поошиктой	2000 төгрөг	
12. 50-ын ууттай	1000 төгрөг	
13. 25-ын ууттай	500 төгрөг	

б/. Тракторын үйлчилгээ

1. Газар ухаж, тэгшлэхэд 1 цаг	50000 төгрөг	
--------------------------------	--------------	--

в/. Ундны усны үйлчилгээ

1. Гүнийн худгийн ус 1 литр	5 төгрөг	
-----------------------------	----------	--

...оОо...



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 07

Бүрэнхайрхан

Амьжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалт, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Амьжиргаа дэмжих зөвлөлийг 2 жилийн хугацаатайгаар дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Н.Бөхчулуун -Сумын Засаг даргын орлогч

Гишүүдэд: Б.Батбаатар –Сумын нэгдсэн эмнэлэгийн дарга

Б.Жавзанпагма -Сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн

Ч.Мухраа - иргэний төлөөлөл Бүрэнхайрхан багийн иргэн

Б.Нэргүй -иргэний төлөөлөл Далт багийн иргэн

А.Хурмаан -иргэний төлөөлөл Баянсудал багийн иргэн

Зөвлөлийн нарийн

бичгийн дарга: Б.Энхзаяа –Сумын Засаг даргын Тамгын газрын хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн

2. Гишүүдэд журмын дагуу урамшууллыг улирал бүр тооцож олгуулж байхыг зөвлөлийн дарга /Н.Бөхчулуун/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 08

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Баянгол дүүргийн иргэн Тулгаа овогтой Алтанцэцэгийг төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-оор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Т. БАТХУЯГ



**ХОВД АЙМАГ
БУЛАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 17 өдөр

Дураар 09

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам", сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Натарцэрэн овогтой Бөхчулууныг төрийн дээд шагнал "Алтан гадагс одон"-оор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА
Хүрэнхайрхан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын дарга
Хүрэнхайрхан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
Хүрэнхайрхан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 10

Бүрэнхайрхан

Зөвшилцлийн санал уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016 оны А/638 тоот захирамж, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын орлогч 2 болсонтой холбогдуулан ажлын туршлагыг харгалзан нийгмийн бодлого хариуцсан орлогчоор Натарцэрэн овогтой Бөхчулууныг, эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогчоор Баатаржав овогтой Гантулгыг томилуулахаар Засаг даргаас ирүүлсэн зөвшилцөх саналыг дэмжсүгэй.

2.Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Н.Бөхчулууныг 2017 оны 07 дугаар сарын 01-нээс чөлөөлж, Намжил овогтой Нарангэрэлийг томилохыг зөвлөсүгэй.

3.Сумын орлогч дарга нарын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 11

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Далт багийн иргэн Жумбай овогтой Буяндалайг Монгол улсын “Соёлын гавъяат зүтгэлтэн”-ээр шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



**ХОВД АЙМАГ
БУЛАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 12

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам", сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТӨТӨОХ нь:
1. Алагтолгой багийн иргэн Мухавай овогтой Баатарыг төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 13

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бүрэнхайрхан багийн иргэн Чойжил овогтой Мухрааг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 14

Бүрэнхайрхан

Г

Сонгуулийн нутаг дэвсгэр,
төвийг тогтоох тухай

Г


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, Сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн нутаг дэвсгэр, төвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА  Т. БАТХУЯГ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны ./. тоот
тогтоолын хавсралт



БУЛГАН СУМЫН СОНГУУЛИЙН НУТАГ ДЭВСГЭР,
ТӨВ БАЙРЛАХ ХУВААРЬ

№	Аймаг, сум	Баг	Газрын нэр
1	Ховд Булган	Баянгол баг	Сонгинот
2	Ховд Булган	Баянсудал	Дээд нарийн
3	Ховд Булган	Байтаг	Сөнхөлд
4	Ховд Булган	Алагтолгой	Бумбат
5	Ховд Булган	Далт	Соёлын төвд
6	Ховд Булган	Бүрэнхайрхан	Минжит Булган цогцолбор сургууль
7	Ховд Булган	Шинэ төв /Хөдөөний 4 багаас сумын төвд зусаж буй сонгогчдын санал авах байр/	12 жилийн 1 дүгээр сургууль

...оОо...



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 15

Бүрэнхайрхан

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.1.14, аймгийн Засаг даргын 2013 оны А/514 дүгээр захирамж, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын тэргүүний баг, байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, ажил мэргэжлийн аварга шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэн мөрдөн ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2016 оны 02 дугаар сарын 04-ны 06 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т. БАТХУЯГ



Тэргүүлэгчдийн 2017 оны 15 тоот
тогтоолын нэгдүгээр хавсралт

**СУМЫН ТЭРГҮҮНИЙ БАГ, БАЙГУУЛЛАГА, ААН, ТББ,
АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Зорилго.

Төрийн хууль, тогтоол, шийдвэр, хөтөлбөрүүдийг бүрэн хэрэгжүүлэх, ажилтан, албан хаагч хөдөлмөрлөх, ажиллах урам зоригийг идэвхижүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, тэдний нэр хүндийг өсгөх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Үндэслэл.

Тухайн жилд сумандаа ажлын хамгийн өндөр амжилт гаргасан иргэн, баг, байгууллага, хамт олны хөдөлмөр бүтээлийг үнэлж, алдаршуулахад оршино.

Шалгаруулах хугацаа.

Жилийн эцсийн дүн мэдээ гарсны дараа жил бүрийн Монголын сар шиний өмнөх долоон хоногт

Шалгаруулах журам.

Сумын Засаг даргын Тамгын газраас томилсон комисс /комиссид ИТХ-ын тэргүүлэгчдийн төлөөллийг зөвшилцөн оролцуулсан байна/ иргэн, баг, байгууллага, салбар, ААН бүрийн тухайн жилд хийж хэрэгжүүлж, баталгаажуулсан ажлын баримтыг үндэслэн үзүүлэлтээр оноог өгч нэгтгэн сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар уламжлуулан эхний гурван байр эзэлсэн иргэн, баг, байгууллага, ТББ, ААН, ажил мэргэжлийн аваргыг ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар баталгаажуулна. Шалгаруулах үзүүлэлт нь байгууллага бүрт тохирхуйц нийтлэг байна. Үзүүлэлтийг 0-10 оноо өгч үнэлнэ.

А/.Төсөвт байгууллага

№	Шалгах үзүүлэлт	Агуулга	Өгөх үнэлгээ
1	Байгууллагын дотоод ажил, шийдвэр гүйцэтгэл /Аймгийн Засаг даргын Тамгын газрын өгсөн үнэлгээг харгалзан дүгнэнэ/	1.Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөөний биелэлт, үр дүн 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл түүний биелэлт, үр дүн, мэдээ тайлан хүргүүлэлт 3. Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, үр дүн 4.Албан хэрэг хөтлөлтийн стандарт, дотоод ажлын эмх цэгц, баримт бичгийн бүрдүүлэлт 5.Архивын байрны тохижуулалт, бичиг хэргийн хадгалалт хамгаалалт	0-10

		<p>6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүн хөдөлмөрийн гэрээ байгуулж дүгнэсэн байдал</p> <p>7. Байгууллагын хэмжээнд эрх зүйн сургалт зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөтэй эсэх, тэдгээрийн хэрэгжилт, эрх зүйн сургалт, сурталчилгааны гарын авлага, арга зүйн удирдлагаар холбогдох байгууллага, мэргэжилтнийг хангасан байдал</p> <p>8. Төрийн албан тушаалын сул орон тоог зарласан эсэх, түр ажлын байрыг нөөцөөс томилсон эсэх, шалгалтанд тэнцээгүй болон шалгалт өгөөгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албан тушаалд ажиллуулж байгаа эсэх.</p> <p>9. Ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалт</p> <p>10. Сумын хэмжээнд бусад салбаруудтай хамтарч ажилласан байдал</p>	
2	Сумын ИТХ-ын тогтоол	Засаг даргын захирамжийн биелэлт	0-5
3	Сумаас зохион байгуулсан ажил, арга хэмжээнд оролцсон байдал	Хурал, цуглаан, зөвлөгөөн, сургалт семинар, байгаль хамгаалах, нийтийг хамарсан бусад ажил арга хэмжээнд оролцсон байдал	0-5
		Иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар санаачлан хийсэн ажил, соёл урлагийн арга хэмжээнд оролцсон байдал	0-3
		Спортын арга хэмжээнд оролцсон байдал	0-4
		Номын сангаар үйлчлүүлсэн байдал	0-2
4	Гэмт хэрэг хэв журмын зөрчил архидан согтуурахтай тэмцэх талаар хийсэн ажил	Гэмт хэргийн байдалд өгөх үнэлгээ	0-2
		Төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, хэвшүүлэх талаар хийсэн ажил, гарсан үр дүн, "Ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилт, байгууллагын ёс зүйн хорооны ажил	0-5
		Архидан согтуурч хэв журам зөрчсөн байдал, архидалтын эсрэг авсан арга хэмжээ	0-5
5	Хууль, тогтоол, дүрэм, тушаал, заавар захирамж сурталчилсан байдал	Хуулийн булан самбар, ухуулга мэдээллийн цаг хэвлэлээр	0-5
		Монгол улсын хуулиуд, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, албан	0-4

		даалгавар, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, салбарын яамдын сайд, аймаг, сумын Засаг даргын захирамж, албан даалгаварын биелэлт, зохиосон ажил, үр дүн	
		“Иргэний өдөр” зохион байгуулсан байдал мэдээ тайлангийн ирц, иргэний өргөдөл, гомдлын барагдуулалт урлаг, соёлын арга хэмжээгээр дамжуулан хууль сурталчилсан байдал	0-5
6	Байгууллагаа тохижуулсан байдал	Гадна орчноо хэрхэн тохижуулсан	0-3
		Шинээр хийсэн хөрөнгө оруулалт	0-4
		Тухайн онд хийсэн бүтээлч ажил дотоод орчноо тохижуулсан байдал	0-4
7	Ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн	Дотоод журмын боловсруулалт, биелэлт, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд олгосон хөнгөлөлт зохиосон ажлын үр дүн	0-5
		Ажиллагсадын ажиллах нөхцлийг сайжруулсан эсэх, тэтгэвэрийн ахмадуудыг хүлээж авсан байдал	0-4
		Гамшгийн бэлэн байдал, бүлэг байгуулсан байдал ажиллагсадын хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангасан эсэх, галын аюулгүй ажиллагааны байр, иж бүрдэл	0-4
8	Төсөв хөрөнгө	Төсвийн орлого зарлагын төлөвлөгөөний биелэлт, өр авлагын барагдуулалт, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, санхүүгийн мэдээ, судалгаа, тайлангийн гаргалт, аймгийн Аудитын газар, Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн албаны байгууллагын төсөв, санхүүгийн холбоотой дүгнэлт	0-3
		Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, төсвийн дотоод хяналт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт үр дүн	0-3
		Өөрийн орлогын биелэлт	0-3
		Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт	0-3
9	Хүүхдийн хөгжил	“Байгууллагын хүүхэд хамгаалалын бодлого”	0-4

	оролцоо, хамгааллын талаар хийсэн ажил	төлөвлөлт, хэрэгжилт хийсэн ажил үр дүн	
		Байгууллагын ажилчдын хүүхдийг хөгжүүлэх талаар хийсэн ажил	0-2
		Эмзэг бүлгийн хүүхэд иргэдэд дэмжлэг үзүүлсэн байдал	0-3
Дүн			100

Шэгнал урамшил

Тэргүүн байр эзэлсэн байгууллагын шилжин явах цом, Батламж олгож байгууллагын даргын цалинг 2 сар 30 хувь цалин нэмэх

2-р байр эзэлсэн байгууллагад Батламж олгож байгууллагын даргын цалинг 20 хувь хоёр сарын цалин нэмэх

3-р байр эзэлсэн байгууллагад Батламж байгууллагын даргын цалинг 10 хувь хоёр сарын цалин нэмэх /3 жил дараалан тэргүүн байр эзэлсэн байгууллагад цомыг үүрд хадгалуулна/.

б/Хувийн хэвшил, салбарууд.

№	Дүгнэх үзүүлэлт	Өгөх үнэлгээ	
1	Хууль, дүрэм, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган зохион байгуулж байгаа байдал, үр дүн /иргэд салбар, ААН-үүдийн хүрээнд/	0-5	
2	ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийн биелэлт, хэрэгжилт үр дүн	0-5	
2	Сумаас зохиосон ажил арга хэмжээнд оролцсон байдал	Хурал, цуглаан, зөвлөгөөн, сургалт, семинарт оролцож, мод тарих, их цэвэрлэгээ нийтийг хамарсан ажил	0-5
		Иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар санаачилан хийсэн ажил, урлаг, спортын арга хэмжээнд оролцсон байдал	0-4
3	Гэмт хэрэг хэв журмын зөрчил архидан согтуурах, тамхидалттай тэмцэх талаар хийсэн ажил	Гэмт хэргийн байдалд өгөх үнэлгээ	0-5
		Тамхины тухай хуулийн хэрэгжилт	0-5
		Архидан согтуурч хэв журам зөрчсөн байдал	0-5
4	ААН, Салбарын тохижилт	Гадна орчны тохижилт ариун цэвэр, нийтийн цэвэрлэгээнд оролцсон байдал	0-5
		Байгууллагадаа оруулсан хөрөнгө оруулалт	0-3
		Нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн онд	0-5

		нийгэм рүү хандаж хийсэн бүтээлч ажил	
		Дотоод орчноо тохижуулсан байдал	0-4
5	Ажиллагсадын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн	Дотоод журмын боловсруулалт, биелэлт, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд олгосон хөнгөлөлт зохиосон ажлын үр дүн	0-5
		Ажлын байр шинээр бий болгож, ажиллагсдын ажиллах нөхцөлийг сайжруулсан байдал	0-5
		Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангасан эсэх, тэтгэврийн ахмадад үзүүлсэн дэмжлэг	0-5
		Эрүүл мэнд, нийгмийн даатгал төлсөн байх	0-5
6	Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын талаар хийсэн ажил		0-3
7	Эмзэг бүлгийн хүүхэд, иргэдэд дэмжлэг үзүүлсэн байдал		0-5
8	ААН, салбарын соёлжилт, хог хаягдал, бие засах газар, бохир усны цооног		0-4
9	ААН, салбарын хашаажилт, зохион байгуулалт, хаягжуулалт		0-4
10	Иргэний өргөдөл гомдлын барагдуулалт		0-4
11	Санхүүгийн мэдээ, судалгаа, тайлангийн гаргалт, Мэргэжлийн хяналтын газрын төлбөрийн өр авлага		0-4
12	Татвар төлбөрийн өр авлага		0-5
Эхний гурван байранд орсон хувийн хэвшил, салбар үзүүлэлт 85 доошгүй байна			
Дүн			100

Шагнал урамшил

Нэгдүгээр байр эзэлсэн хувийн хэвшил, салбарын шилжин явах цом, Батламж

Хоёрдугаар байр эзэлсэн хувийн хэвшил салбарт Батламж олгоно

Гуравдугаар байр эзэлсэн хувийн хэвшил салбарт Батламж олгоно. /3 жил дараалан тэргүүн байр эзэлсэн хувийн хэвшил салбарт цомыг үүрд хадгалуулна/.

в/Багийн ажлыг дүгнэх үзүүлэлт

№		Өгөх
	Дүгнэх үзүүлэлт	0-5
1	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж байгаа байдал, үр дүн /Иргэд, байгууллагын хүрээнд/	0-5
2	Багийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	0-5
3	“Багийн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн биелэлт, бодит	0-5
4	Боловсролын байгууллагуудтай хамтарч ажилласан эсэх, багийн хүүхдүүдийн СӨБ, гэр цэцэрлэг, сургууль, иргэдийг насан туршийн боловсролд хамрагдалт	0-5

5	Иргэдэд мэдээлэл хүргэх арга хэлбэр, үр дүн		0-5
6	Судалгаа	Амьжиргааны түвшингийн судалгаа	0-3
		Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	0-3
		Хүн ам зүйн төрөлжсөн судалгаа	0-3
7	Гаргасан захирамж шийдвэр, үр дүн /захирамжийн тоо/		0-4
8	Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, шагналын тодорхойлолтын талаар		
9	Эмнэлэг, эрүүл мэндийн чиглэлээр хийсэн ажил		
10	Ахмадуудыг сувилалд хамруулсан байдал		
11	Багийн Засаг даргын албан хэрэг хөтлөлтийг архив, албан хэрэг хөтлөлтийн журам зааварт нийцсэн байдал		0-4
12	Багийн ИНХ зохион байгуулсан байдал, өдөрлөг зохион байгуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлсэн байдал, хурлын ирц		0-8
13	Багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэгжүүлсэн байдал	Нийгмийн хэв журмын зөрчил	0-5
		Гэмт хэргийн гаралт	0-4
14	Тухайн жил, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт		0-5
15	Худаг уст цэгийн ашиглалт, хамгаалалт		0-3
16	Мал эмнэлгийн үйлчилгээг зохион байгуулж байгаа байдал		0-5
17	Хүүхдийн эрүүл мэнд, хөгжил оролцоо, хамгаалалын талаар хийсэн ажил		0-5
18	Гамшгийн бэлэн байдал, цэргийн үүрэгтний бүртгэл тооцоо		0-8
19	Айл өрхүүдийн хашаажилт, зохион байгуулалт, соёлжилт, хаягжуулалт, хог хаягдал, багийн төвийн тохижилт		0-5
20	Сум орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан урлаг, спортын арга хэмжээнд оролцсон байдал, санаачилан хийсэн ажил		0-5
21	Төрийн бус байгууллагатай хамтарч ажилласан байдал		
Дүн			100

Шагнал урамшил

Нэгдүгээр байр эзэлсэн багийг шилжин явах дарцаг, Батламж олгож багийн Засаг даргын цалинг 1 сар 20 хувь нэмнэ. /3 жил дараалан тэргүүн байр эзэлсэн багт дарцагийг үүрд хадгалуулна/.

Хоёрдугаар байр эзэлсэн багт Батламж олгож, багийн даргын цалинг 10 хувь нэг сарын цалин нэмнэ.

г/. Төрийн бус байгууллагын ажлыг дүгнэх үзүүлэлт

№	Дүгнэх үзүүлэлт	Өгөх
1	ИТХ, Засаг даргын захирамж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг	0-7

	хангаж ажиллаж байгаа талаар		
2	Сумаас зохиосон ажил арга хэмжээнд оролцсон байдал	Хурал, цуглаан, зөвлөгөөн, сургалт, семинарт оролцож, мод тарих, их цэвэрлэгээ нийтийг хамарсан ажил	0-5
		Иргэдтэй хамтарч ажилласан байдал, санаачилж хийсэн ажил	0-5
3	Хуулийн хэрэгжилт Архидан согтуурах, тамхидалттай тэмцэх талаар хийсэн ажил	Хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн ажил	0-5
4	Тогтмол үйл ажиллагаа явуулдаг байртай эсэх, орчны тохижилт		0-5
5	Нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн онд нийгэм рүү хандаж хийсэн ажил		0-8
6	Хүүхэд хамгааллын талаар хийсэн ажил		0-5
7	Хүүхэд, гэр бүл, ахмад настанд дэмжлэг үзүүлсэн байдал		0-5
8	Дотоод бичиг хэрэг		0-8
Дүн			50

д/. Сумын ажил, мэргэжлийн аварга шалгаруулах журам.

Зорилго.

Тухайн жилд сумандаа ажил, хөдөлмөр, урлаг, спорт, уран бүтээл, сурлагын хамгийн өндөр амжилт гаргасан алдартнуудын хөдөлмөр бүтээлийг үнэлж алдаршуулах.

Хугацаа: Баг, байгууллага, ААН-үүдийн дарга, захирал, эрхлэгч, нар ажил мэргэжлийн аваргаар тодорхойлох хүмүүсийнхээ тодорхойлолтыг журмын дагуу жил бүрийн сар шиний өмнөх долоо хоногийн даваа гариг бүрт тухайн жилд хийсэн ажлын амжилтыг нь баримтжуулан хавсаргаж баг, хамт олны хурлаар хэлэлцэн шийдвэрлэн Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн байна.

1. Сумын тэргүүний хүүхэд.

Сурлагын амжилт, танин мэдэхүй, урлаг, уран бүтээл, биеийн тамир спорт, бие бялдарын хөгжил, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, хөдөлгөөн хамт олны удирдлага, зохион байгуулалт, бүтээлч, ажилч хичээнгүй байдал, мэргэжлийн чиг баримжаа, хүмүүнлэг энэрэнгүй үйлс, ёс суртахууны чанар, техник сэтгэлгээ, шинийг сэдэх санаачилга, байгаль хамгаалах, эрүүл аюулгүй орчин, эх орны түүх соёл, өв уламжлалаа хүндэтгэн сахидаг бусаддаа үлгэрлэн дууриалал үзүүлэхэд тухайн жилд хамгийн өндөр шалгуурыг хангасан 2-оос доошгүй хүүхэд байна.

2. Сумын тэргүүний залуу

Ажлын амжилт, урлаг, уран бүтээл, биеийн тамир спорт, залуучуудын байгууллага, хөдөлгөөн хамт олны удирдлага, зохион байгуулалт, нийгэм рүү

хандсан ажил зохион байгуулсан байдал, бүтээлч ажилч хичээнгүй байдал, хүмүүнлэг энэрэнгүй үйлс, ёс суртахууны чанар, техникийн сэтгэлгээ, шинийг сэдэх санаачилга, байгаль хамгаалах, эрүүл аюулгүй орчин эх орны түүх соёл, өв уламжлалаа хүндэтгэн сахидаг бусаддаа үлгэрлэн дууриалал үзүүлэхэд тухайн жилд хамгийн өндөр шалгуурыг хангасан 3-аас доошгүй залуу байна.

3. Сумын тэргүүний үйлчилгээний ажилтан

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаа үйлчилгээний ажилтнуудаас тухайн жилдээ эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан ажилтан байна.

4. Боловсролын тэргүүний ажилтан

Боловсролын салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа, бүтээлч хичээнгүй шинийг сэдэх, зохион байгуулалт сайтай, хүүхдийг хөгжүүлэх олон талт ажил зохион байгуулсан байдал, ёс суртахууны зөв үлгэр дууриалалтай, улс аймаг, сумаас зохиосон уралдаан тэмцээнд өөрөө болон шавь нар нь амжилттай оролцож ирсэн тухайн жилд ажил мэргэжлийн чиглэлээрээ байгууллагадаа хамгийн өндөр шалгуур хангасан дарга эсвэл ажилтан байна.

5. Эрүүл мэндийн тэргүүний ажилтан

Эрүүл мэндийн салбарт үр бүтээлтэй, идэвхи санаачилгатай ажиллаж нийгмийн эрүүл мэндийг хамгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажилд бусдыгаа хошуучлан үр дүн гаргаж тухайн жилд ажил мэргэжлээрээ байгууллагадаа хамгийн өндөр үзүүлэлт гаргасан дарга эсвэл ажилтан байна.

6. Төрийн тусгай болон төрийн захиргааны тэргүүний ажилтан

Байгууллага хамт олноо хошуучлан, идэвхи санаачилгатай ажиллаж тухайн жилдээ амжилт гаргасан төрийн тусгай, төрийн захиргаа, улс төрийн албан хаагч байна.

7. Сумын тэргүүний тариаланч

Газар тариалангийн ажлыг тухайн жилдээ үр бүтээлтэй эрхлэж, үр тариа, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэний га-гаас авах ургацыг жилээс жилд нэмэгдүүлж, талбайдаа ойн зурвас байгуулсан, ард иргэдийг хямд үнэтэй бүтээгдэхүүнээр жилийн 4 улиралд ханган, ажлын байр шинээр бий болгож, ажилчдынхаа нийгмийн даатгалын шимтгэл, татвар төлсөн байх.

Сумын тэргүүний малчин

Мал сүргээ 5 төлөөр нь өсгөж бодод шилжүүлснээр 120-с дээш толгой малтай, малгүй өрхийг малжуулж, олон нийтийн байгууллагад дэмжлэг үзүүлж, туслах малчин авч ажиллуулж ажлын байр бий болгон мал сүргээ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сүргийн зохистой бүтцийг бий болгон, өөрсдөө нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан, өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаатай, МАА-н үйлдвэрлэл дээр 5-с доошгүй жил тасралтгүй ажилласан 3 хүртлэх малчныг шалгаруулах бөгөөд өндөр үзүүлэлттэй нэг малчныг сумын сайн малчнаар тодруулна.

8. Сумын тэргүүний бизнесмен

Сумын хэмжээнд жижиг дунд бизнес үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, иргэд залуучуудын мэдлэг боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулж тухайн жилд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд сумын хэмжээнд бодит хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж, бизнесмен байна.

Шагнал урамшил

Ажил мэргэжлийн аваргуудыг тодруулан энгэрийн тэмдэг, тус бүр 50.000 төгрөгөөр шагнаж, зургийг нь хүндэт самбарт тавьж алдаршуулна.

_____оОо_____



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 16

Бүрэнхайрхан

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтууд, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ерөнхий боловсролын 12 жилийн 1 дүгээр сургуулийн 80 жилийн ойгоор төгсөгчид, ард иргэдээс хандивласан машин тоног төхөөрөмжийг /компьютер/ 1 дүгээр хавсралтаар, тавилга, аж ахуйн эд хогшил 2 дугаар хавсралтаар, ном, бусад үндсэн хөрөнгийг 3 дугаар хавсралтанд заагдсаны дагуу хөрөнгийг балансад бүртгэхийг тус сургуулийн захирал /С.Баярсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг 12 жилийн 1 дүгээр сургуулийн захирал /С.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг бүртгэлд тусгуулан, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг сумын өмч хамгаалах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 17

Бүрэнхайрхан

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтууд, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Минжит Булган цогцолбор сургуульд “Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилт, хувь хүний дэмжлэгтэйгээр худалдаж авсан 17 нэр төрлийн хөрөнгийг 1 дүгээр хавсралтанд заагдсаны дагуу хөрөнгийг балансад бүртгэхийг тус сургуулийн захирал /Ц.Сонгууль/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Минжит Булган цогцолбор сургуулийн захирал /Ц.Сонгууль/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийг бүртгэлд тусгуулан, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг сумын өмч хамгаалах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 18

Бүрэнхайрхан

Г

Хөрөнгө бүртгэх тухай

Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтууд, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сарнай цэцэрлэгт эцэг эх, иргэдийн хандиваар хандивласан машин тоног төхөөрөмж /компьютер/-ийг 1 дүгээр хавсралт, тавилга, аж ахуйн эд хогшлийг 2 дугаар хавсралтанд заагдсаны дагуу хөрөнгийг балансад бүртгэхийг цэцэрлэгийн эрхлэгч /О.Түмэнжаргал/-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгч /О.Түмэнжаргал/-д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг бүртгэлд тусгуулан, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг сумын өмч хамгаалах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 19

Бүрэнхайрхан

Сумын ажил, мэргэжлийн
аварга шалгаруулах тухай

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 06-ны 15 тоот тогтоолоор батлагдсан сумын тэргүүний баг, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, ажил мэргэжлийн аварга шалгаруулах журам, Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын тэргүүний баг, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, ажил мэргэжлийн аваргыг хавсралтаар баталсугай.

2. Шагнал, урамшуулалын зардлыг зохих журмын дагуу олгохыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





Нэг.Сумын ажил, мэргэжлийн аварга

1.Төрийн тусгай болон төрийн захиргааны тэргүүний ажилтан

Х.Нэгдэлхаан

2.Сумын тэргүүний үйлчилгээний үйлчилгээний ажилтан

Ц.Шарцэцэг

3.Боловсролын тэргүүний ажилтан

Г.Даваасүрэн

4.Эрүүл мэндийн тэргүүний ажилтан

А.Шинэжил

5.Сумын тэргүүний тариаланч

М.Ганболд

6.Сумын тэргүүний малчин

Д.Батсүх

7.Сумын тэргүүний бизнесмен

Ш.Батгэрэл

8.Сумын тэргүүний залуу

Х.Хаш-эрдэнэ

9.Сумын тэргүүний сурагч

Н.Мөнхтуул

Хоёр. Сумын аварга малчин

Ж.Сүхбаатар

Т.Батцоож

А.Тихат

Ш.Майбаяр

Гурав.Сумын тэргүүний байгууллага

1.Цагдаагийн хэлтэс

2.Прокурор

3.Минжит Булган цогцолбор сургууль

Дөрөв.Сумын тэргүүний хувийн хэвшил

1.Залуучуудын холбоо

2.Мобиком

3.Тэс петролиум



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 20

Бүрэнхайрхан

Санал уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын Баянгол багийн нутаг Баянголын амны 60 га, Намсрайн дугуйн 30 га, Махны хар үзүүр зуухад 60 га, Хар үзүүрийн услалтын систем 140 га, Давхар эргийн услалтын систем 135 га, Баянсудал багийн Загийн улаан 100 га, Байтаг багийн Даржаан хотгор 60 га, Алагтолгой багийн ангис 60 га, Сумын төв 60 га талбай, нийт 705 га талбайг тариалангийн бүс нутгаар тогтоолгох саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.

2.Тариалангийн бүс нутаг түүний заагийг тогтоох тухай шийдвэрийг гаргуулан хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 21

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, сумын Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын алдарт эхчүүдийн 1, 2 дугаар зэргийн одонгийн болзол хангасан 42 иргэний материалыг хавсралтаар баталж дэмжсүгэй.


2.Материалыг холбогдох байгууллагад уламжлан хүргүүлэхийг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 4 тоот
тогтоолын хавсралт



БУЛГАН СУМААС АЛДАРТ ЭХИЙН I, II ОДОНД
ХАМРАГДАХ ЭХЧҮҮДИЙН СУДАЛГАА

2017.03.07.

№	Овог	Нэр	Баг	Хүүхдийн тоо		Тайлбар
				Одон	Одон	
1	Хавалхат	Гүльбахша	Баянгол	6	I	
2	Жүнсбек	Бахатгүль	Баянсудал	6	I	
3	Амаан	Саяахат	Бүрэнхайрхан	6	I	
4	Хуанбай	Өнөргүль	Баянсудал	6	I	
5	Хали	Тохтус	Баянгол	7	I	
6	Зардаах	Аянагүль	Баянсудал	6	I	
7	Хоной	Мерзетхан	Баянсудал	6	I	
8	Маман	Жангүл	Бүрэнхайрхан	6	I	
9	Магазам	Хэнжэгүл	Баянсудал	6	I	
10	Ачбай	Күнсауле	Баянсудал	6	I	
11	Мадьян	Залиман	Баянгол	4	II	
12	Жанайхан	Дарийгүл	Баянгол	4	II	
13	Иргэбай	Саяа	Баянсудал	4	II	
14	Хавалхан	Аянагүль	Баянгол	4	II	
15	Дамдиндорж	Өнөрцэцэг	Алагтолгой	4	II	
16	Банди	Болормаа	Далт	4	II	
17	Рамбек	Алтангүл	Баянсудал	4	II	
18	Гэрэлчулуун	Ууганбаяр	Алагтолгой	4	II	
19	Шилэг	Ганцэцэг	Баянгол	4	II	
20	Идээ	Нямбилэг	Баянгол	4	II	
21	Баттулга	Энхцэцэг	Баянгол	4	II	
22	Даш	Баярмаа	Байтаг	4	II	
23	Рамбек	Алтнай	Баянсудал	4	II	
24	Чөтөг	Хулан	Баянсудал	4	II	
25	Дашдондог	Ариунжаргал	Далт	4	II	
26	Жумаахан	Даригүль	Баянсудал	4	II	
27	Зайтан	Хадуу	Байнсудал	4	II	
28	Нухтархан	Телубай	Алагтолгой	4	II	
29	Дамежен	Мадина	Баянгол	4	II	
30	Хэнжхан	Латипа	Баянсудал	4	II	
31	Аманбай	Мерекей	Баянсудал	4	II	
32	Магаа	Ганцэцэг	Баянгол	4	II	
33	Баавдай	Атар	Бүрэнхайрхан	4	II	
34	Энэбиш	Мөнхцэцэг	Байтаг	4	II	
35	Хашбаатар	Анхбаяр	Байтаг	4	II	
36	Сүхтэй	Мэндсайхан	Баянгол	4	II	
37	Баатар	Уранчимэг	Байтаг	5	II	
38	Кагин	Чарихан	Баянсудал	4	II	1 хүүхэд нь 2 настайдөө өвчнөөр

						нас барсан
39	Лоорой	Батцэцэг	Алагтолгой	4	II	1 хүүхэд нь 1 настайдаа гэртээ нас барсан
40	Хатанбаатар	Дэжидхүү	Алагтолгой	4	II	1 хүүхэд нь 2 настайдаа авто ослоор нас барсан
41	Загд	Мэндсайхан	Баянгол	4	II	1 хүүхэд 2 настайдаа өвчнөөр нас барсан
42	Бүүвэй	Байгалмаа	Баянгол	4	II	1 хүүхэд 9 настайдаа бусад ослоор нас барсан

...оОо...



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 22

Бүрэнхайрхан

Г Гэрийн мод олгох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Ойн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь заалт, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэрийн мод авахыг хүссэн 25 иргэнд Байтаг, Баянгол багт хамгаалалттай талбай, Шуудай, Балжин, Хонгион задгай талбай, Алагтолгой багт хамгаалагдсан талбай, Майхан уулаас дээш задгай талбайнаас гэрийн мод олгох, нэг гэрийн модыг хоёр куб/метр буюу 180000 төгрөг /нэг зуун наян мянган/-өөр тооцон олгохыг зөвшөөрсүгэй.

2. Мод олгох ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т. БАТХУЯГ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 22 тоот
тогтоолын хавсралт



ГЭРИЙН МОД АВАХ ИРГЭДИЙН НЭРС

2017.03.07.

№	Овог нэр	Баг	Газрын нэр
1	М.Мерейхан	Баянгол	Баяндайн тор
2	А.Ариунбат	Баянгол	Баяндайн тор
3	Б.Анхбаяр	Баянгол баг	Дадаан тор
4	Д.Батдорж	Баянсудал	Төмөржөөн тор
5	А.Тусхаан	Баянсудал	И.Батсуурийн тор
6	Х.Жалел	Баянсудал	Шуудайгаас
7	Б.Ууганбаатар	Байтаг	Байтаг Улиаст
8	Н.Тулгаа	Байтаг	Байтаг Улиаст
9	Ж.Мөнхдалай	Байтаг	Орломцоо тор
10	н.Пунцаг	Байтаг	Байтаг Улиаст
11	Б.Жаргалсайхан	Алагтолгой	Майхан толгой
12	Д.Батхүү	Алагтолгой	Майхан толгой
13	Б.Гантөмөр	Алагтолгой	Байгалийн сайхан
14	П.Батаа	Алагтолгой	Яам "задгай"
15	П.Нацагдорж	Далт	Хөх тохой
16	Б.Цэдэнсамбуу	Далт	Энхтайваны тор
17	Х.Баяраа	Далт	Энхтайваны тор
18	Ш.Гантөмөр	Далт	Орломцоо тор
19	Н.Цэрэндорж	Далт	Шуудуй "задгай"
20	О.Баатарсүрэн	Далт	Дамбий тор
21	Г.Сайханбилэг	Бүрэнхайрхан	Орломцоо тор
22	Т.Батсуурь	Бүрэнхайрхан	Нямаан тор
23	С.Эрдэнэцэцэг	Бүрэнхайрхан	Хонгио "задгай"
24	А.Мөнхбаатар	Бүрэнхайрхан	Орломцоон тор
25	Х.Баянмөнх	Бүрэнхайрхан	Ч.Баянмөнхийн тор



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 23

Бүрэнхайрхан

“Сумын хүндэт иргэн” өргөмжлөх
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 16-ны 23 тоот тогтоол, Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Машин механизмын үйлдвэрлэл, угсралтын салбарт амжилт гарган ажиллаж Монгол улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цолоор шагнагдсан Даньдай овогтой Жаргалсайхан, эрчим хүчний салбарт амжилт гарган ажиллаж Монгол улсын эрчим хүчний гавъяат ажилтан цолоор шагнагдсан Гончоо овогтой Түвшин, Соёл урлагийн салбарт амжилт гарган Монгол улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цолоор шагнагдсан Дашдэндэв овогтой Алтантуул, бизнесийн салбарт 2017 онд амжилт гарган ажиллаж Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бүтээн байгуулалтын дээд шагнал “Төрийн гэрэгэ”-р шагнагдсан Натурал текстал группын ерөнхий захирал Шагдарсүрэн овогтой Энхбаяр нарыг “Сумын хүндэт иргэн”-ээр тус тус өргөмжилж алдаршуулсугай.

2.Сумын “Хүндэт иргэн”-ий энгэрийн тэмдэг, үнэмлэхийг журмын дагуу олгохыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 24

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Далт багийн иргэн Цэвгээ овогтой Алтанбайг төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-оор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





**ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 25

Бүрэнхайрхан

Хөрөнгө данснаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.7, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд бүртгэлтэй нэг бүрийн үнэ нь 1000 төгрөгийн үнэтэй 20 ширхэг улиасыг данснаас хассугай.

2. Улиасыг Засаг даргын Тамгын газрын бүртгэлээс хасаж, орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг өмч хамгаалах зөвлөлийн дарга /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 26

Бүрэнхайрхан

Г Сонгуулийн сурталчилгааны самбарын
тоо, хэмжээ байршлыг тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, Монгол Улсын сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.8 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгуулийн сурталчилгааны зурагт болон ухуулах хуудсийг гудамж, талбай, олон нийтийн газарт байрлуулах байршлыг нам, эвсэл, нэр дэвшигчийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг баримтлан албан ёсны зөвшөөрөлтэй самбарын тоог 200 хүртэл, сонгуулийн сурталчилгааны самбарын хэмжээг жижиг 1 тал нь 5м²-аас ихгүй дунд 1 тал нь 30м²-аас ихгүй, том 1 тал нь 120м²-аас ихгүй байхаар тус тус тогтоосугай.

2. Сумын төвийн дүүрэгт байрлуулах байршлын дээд цэг нь Хөрс авто сервис ХХК-ны шатахуун түгээх станц, урьд цэг нь Гаалийн хашааны урьд өнцөг, доод цэг нь Зэвсэгт хүчний 305 дугаар ангийн цементэн гүүр, хойд цэг сумын төв гудамжаар хязгаар тогтоосугай.

3. Багуудад байршуулах самбарын байршлыг багийн төвөөс 200 метр дотор тогтоосугай.

4. Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг нам, эвсэл, нэр дэвшигч нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т. БАТХУЯГ





**ХОВД АЙМАГ
БУЛАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛГӨДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 24 өдөр

Дураар 27

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам", сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Булан сумын Бүрэнхайрхан багийн иргэн Лоопрой овогтой Баатаржавыг төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА
Т. БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 28

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Булган сумын Далт багийн иргэн өндөр настан Содов овогтой Баастыг төрийн дээд шагнал “Байгаль орчны гавъяат ажилтан ” цолоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 29

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Пүрэв овогтой Оюуныг төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Т.БАТХУЯГ